



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/355

Мөрөн сум

Улсын асрамжид шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.1, 19.4, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”-ын 5.1, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэр бүхий иргэний Төв аймгийн улсын асрамжид шилжих хүсэлт, Мөрөн сумын Элст багийн Засаг дарга, сумын Засаг дарга, Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан тоотоор ирүүлсэн хүсэлтүүдийг харгалзан асран хамгаалах үр хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ахмад настан Санжаа овогтой Баднаанямбууг 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Төв аймгийн улсын асрамжийн газарт шилжүүлсүгэй.

2. С.Баднаанямбууг Төв аймгийн улсын асрамжийн газарт шилжүүлэхтэй холбоотой ажлыг зохих журмын шуурхай зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Т.Раднаабүд), Ахмад настны асрамж үйлчилгээний төв (Т.Октябрьбаяр)-ийн удирдлагуудад даалгасугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН